



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2023/99/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2023 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА  
Б.МӨНХБАЯР ТАНАА

2023.02.15 № 2/20

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг

005020158

хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>258,193,864.05</b>	<b>253,860,719.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	19,716,340.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	19,716,340.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	19,716,340.00
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	19,716,340.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	44,027,641.00	14,691,600.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	44,027,641.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	14,691,600.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	14,691,600.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	214,166,223.05	219,452,779.69
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	91,282,859.65	99,946,684.29
35110	Тусгай зориулалттай материал	88,491,239.65	97,863,969.29
35130	Эм боох материал	2,791,620.00	2,082,715.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	630,000.00	630,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	61,798,754.40	74,487,791.40
35410	Бичиг хэргийн материал	3,415,275.00	9,026,455.00
35420	Аж ахуйн материал	00.00	1,089,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,479,500.00	1,479,500.00
35440	Түлш, шатах тослох материал	14,907.00	8,146,387.00
35450	Барилгын засварын материал	11,320,000.00	878,000.00
35470	Бусад хангамжийн материал	45,569,072.40	53,867,849.40
35600	Мал амьтад	60,454,609.00	44,388,304.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,954,395,500.67</b>	<b>3,960,811,300.65</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,954,395,500.67	3,960,811,300.65
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,690,977,500.67	3,697,393,300.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,378,746,447.05	3,464,153,142.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-324,061,318.78	-421,899,712.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	637,407,135.15	767,509,343.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-304,709,442.92	-417,129,615.07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	591,201,634.14	676,273,431.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-333,663,728.26	-411,926,889.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,010,400.40	85,500,924.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,259,262.11	-74,392,959.47
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	29,305,636.00	29,305,636.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	263,418,000.00	263,418,000.00
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-725,000.00	-725,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	263,418,000.00	263,418,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,212,589,364.72</b>	<b>4,214,672,020.34</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>129,200.00</b>

**Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

413	Өглөг		00.00	129,200.00
4136	Бусад өглөг		00.00	129,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг		00.00	129,200.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>4,212,589,364.72</b>	<b>4,214,542,820.34</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>4,212,589,364.72</b>	<b>4,214,542,820.34</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
51101	Өмч: - төрийн		975,948,623.99	975,948,623.99
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>2,786,378,228.90</b>	<b>2,788,331,684.52</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		2,786,378,228.90	2,786,378,228.90
51220	Тайлант үеийн үр дүн		00.00	1,953,455.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		450,262,511.83	450,262,511.83
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>4,212,589,364.72</b>	<b>4,214,672,020.34</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,448,578,969.71</b>	<b>3,457,299,532.84</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>484,494,177.71</b>	<b>412,654,706.84</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	484,494,177.71	412,654,706.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	113,255,020.00	113,614,838.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93,742,933.00	97,752,767.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,356,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,512,087.00	8,505,671.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	325,055,538.98	283,097,844.4
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	46,183,618.73	15,942,024.44
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,964,084,792.00</b>	<b>3,044,644,826.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,760,862,300.00</b>	<b>3,002,347,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,760,862,300.00	3,002,347,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>203222492.00</b>	<b>42297226.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131.894.000.00	15,990,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71.328.492.00	26,067,226.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,263,659,577.06</b>	<b>3,455,163,833.83</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,263,659,577.06</b>	<b>3,455,163,833.83</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,236,456,035.06</b>	<b>3,421,763,043.98</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,397,470,026.00</b>	<b>2,514,352,959.15</b>
210101	Үндсэн цалин	1,459,836,423.00	1,466,899,552.15
210102	Нэмэгдэл	870,463,192.00	937,620,619.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	420,000.00
210104	Урамшуулал	00.00	41,660,178.00
210105	Гэрээт ажлын хөлс	67,170,411.00	67,752,610.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,420,116.00</b>	<b>53,691,242.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,069,827.00	1,824,490.00

**Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	232,663.00	182,436.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	186,131.00	177,889.00
210204	Ажилгүйдлийн даатгал	46,531.00	42,423.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,884,964.00	51,464,004.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>172,404,800.00</b>	<b>184,766,338.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	18,426,532.00	20,039,505.00
210302	Түлш, халаалт	134,212,832.00	143,281,035.00
210303	Цэвэр, бохир ус	19,765,436.00	21,445,798.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>157,353,456.00</b>	<b>166,422,995.00</b>
210401	Бичиг хэрэг	22,521,980.00	24,754,780.00
210402	Тээвэр, шатахуун	115,171,126.00	108,841,218.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,542,350.00	10,332,683.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	636,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,368,000.00	21,857,414.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,470,077.00</b>	<b>72,613,938.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,347,877.00	2,755,165.00
210502	Хоол, хүнс	40,990,200.00	69,858,773.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>45,307,457.00</b>	<b>45,656,350.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,231,000.00	1,334,500.00
210604	Урсгал засвар	44,076,457.00	44,321,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,930,000.00</b>	<b>11,489,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,930,000.00	11,489,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>92,701,295.00</b>	<b>36,320,621.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,341,312.00	32,967,033.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,000.00	1,790,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	484,000.00	567,000.00
210807	Газрын төлбөр	550,000.00	530,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,470,983.00	465,888.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>255,398,808.06</b>	<b>336,449,600.83</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,764,700.00	3,294,689.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	253,634,108.06	333,154,911.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,203,542.00</b>	<b>33,400,789.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,420,000.00</b>	<b>7,477,543.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	704,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,920,000.00	6,773,543.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,783,542.00</b>	<b>25,923,246.85</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,783,542.00	25,923,246.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>184,919,392.65</b>	<b>2,135,699.01</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>18606716.40</b>	<b>182243.39</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	18,606,716.40	182,243.39
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(18,606,716.40)</b>	<b>(182,243.39)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>166,313,676.25</b>	<b>1,953,455.62</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,059,827,725.00</b>	<b>3,177,235,573.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>93,742,933.00</b>	<b>129,097,107.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	93,742,933.00	129,097,107.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,742,933.00	129,097,107.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93,742,933.00	97,752,767.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		31,344,340.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,966,084,792.00</b>	<b>3,048,138,466.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,760,862,300.00	3,002,347,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,760,862,300.00	3,002,347,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	205,222,492.00	45,790,866.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,328,492.00	15,990,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	131,894,000.00	29,560,866.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,988,927,725.00</b>	<b>3,144,864,123.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,988,927,725.00</b>	<b>3,144,864,123.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,962,661,155.00</b>	<b>3,101,926,533.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,397,579,900.00	2,553,142,098.15
210101	Үндсэн цалин	1,310,421,800.00	1,404,323,051.00
210102	Нэмэгдэл	1,050,815,600.00	1,044,909,742.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	420,000.00
210104	Урамшуулал	00.00	67,146,904.50
210105	Гэрээт ажлын хөлс	36,342,500.00	36,342,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,444,563.00	52,814,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	51,444,563.00	52,814,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	172,404,800.00	174,910,200.00
210301	Гэрэл, цахилгаан	20,173,000.00	20,254,555.00
210302	Түлш, халаалт	134,212,832.00	133,424,897.00
210303	Цэвэр, бохир ус	18,018,968.00	21,230,748.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	121,842,300.00	160,916,459.00
210401	Бичиг хэрэг	18,872,000.00	28,120,840.00
210402	Тээвэр, шатахуун	87,716,170.00	114,015,036.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,674,130.00	10,567,683.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	636,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,800,000.00	7,576,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	35,887,100.00	36,149,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	1,289,500.00
210502	Хоол, хүнс	35,087,100.00	33,449,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,410,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,570,000.00	35,349,010.00

**Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,094,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,800,000.00	2,287,310.00
210604	Урсгал засвар	27,770,000.00	27,966,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,930,000.00</b>	<b>11,489,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,930,000.00	11,489,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>141,502,492.00</b>	<b>74,772,366.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138,367,492.00	71,768,866.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,000.00	1,790,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	730,000.00	682,800.00
210807	Газрын төлбөр	550,000.00	530,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,383,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,383,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,266,570.00</b>	<b>42,937,589.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,420,000.00</b>	<b>17,014,343.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	10,686,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,920,000.00	6,328,343.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,846,570.00</b>	<b>25,923,246.85</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,846,570.00	25,923,246.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>70,900,000.00</b>	<b>32,371,450.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>70,900,000.00</b>	<b>12,655,110.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>70,900,000.00</b>	<b>12,655,110.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>70,900,000.00</b>	<b>12,655,110.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	70,900,000.00	12,655,110.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-70,900,000.00</b>	<b>-12,655,110.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>19,716,340.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>19,716,340.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

					/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,602,516,465.85	4,046,276,688.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	17,549,086.80	17,549,086.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,620,065,552.65	4,063,825,775.27
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	-17,549,086,80	00,00	-17,549,86,80
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	166,312,676,25	166,312,676,25
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	450,262,511.83	2,786,378,228.90	4,212,589,364.72
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	450,262,511.83	2,786,378,228.90	4,212,589,364.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

**Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>975,948,623.99</b>	<b>450,262,511.83</b>	<b>2,786,378,228.90</b>	<b>4,212,589,364.72</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,953,455.62	1,953,455.62
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>975,948,623.99</b>	<b>450,262,511.83</b>	<b>2,788,331,684.52</b>	<b>4,214,542,820.34</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,074,265,600.00	3,074,177,120.15	88,479.85	100%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,074,265,600.00	3,074,177,120.15	88,479.85	100%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,057,242,500.00	3,057,162,777.15	79,722.85	100%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,553,142,100.00	2,553,142,098.15	1.85	100%
210101	Үндсэн цалин	1,472,512,600.00	1,404,323,051.00	68,189,549.00	95%
210102	Нэмэгдэл	1,014,287,100.00	1,044,909,742.65	-30,622,642.65	103%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	420,000.00	-420,000.00	
210104	Урамшуулал	30,000,000.00	67,146,904.50	-37,146,904.50	224%
210105	Гэрээт ажлын хөлс	36,342,400.00	36,342,400.00	0.00	100%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,814,700.00	52,814,700.00	0.00	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	52,814,700.00	52,814,700.00	0.00	100%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	174,910,200.00	174,910,200.00	0.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	24,300,000.00	20,254,555.00	4,045,445.00	83%
210302	Түлш, халаалт	133,195,100.00	133,424,897.00	-229,797.00	100%
210303	Цэвэр, бохир ус	17,415,100.00	21,230,748.00	-3,815,648.00	122%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	160,916,600.00	160,916,459.00	141.00	100%
210401	Бичиг хэрэг	27,584,300.00	28,120,840.00	-536,540.00	102%
210402	Тээвэр, шатахуун	114,344,900.00	114,015,036.00	329,864.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,774,500.00	10,567,683.00	206,817.00	98%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,900.00	636,900.00	0.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,576,000.00	7,576,000.00	0.00	100%
2105	<b>Нормативт зардал</b>	36,169,200.00	36,149,400.00	19,800.00	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.00	1,289,500.00	0.00	100%
210502	Хоол, хүнс	33,449,700.00	33,449,700.00	0.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.00	1,410,200.00	19,800.00	99%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,087,400.00	37,054,120.00	33,280.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,800,000.00	6,799,910.00	90.00	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,313,300.00	2,287,310.00	25,990.00	99%
210604	Урсгал засвар	27,974,100.00	27,966,900.00	7,200.00	100%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	11,493,900.00	11,489,000.00	4,900.00	100%
210702	Дотоод албан томилолт	11,493,900.00	11,489,000.00	4,900.00	100%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	28,325,100.00	28,303,500.00	21,600.00	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,300,000.00	25,300,000.00	0.00	100%

**Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,790,000.00	1,790,000.00	0.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	648,600.00	682,800.00	-34,200.00	105%
210807	Газрын төлбөр	586,500.00	530,700.00	55,800.00	90%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2383300.00</b>	<b>2383300.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,383,300.00	2,383,300.00	0.00	100%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17023100.00</b>	<b>17014343.00</b>	<b>8,757.00</b>	<b>100%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,023,100.00</b>	<b>17,014,343.00</b>	<b>8,757.00</b>	<b>100%</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,686,000.00	10,686,000.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,337,100.00	6,328,343.00	8,757.00	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,074,265,600.00</b>	<b>3,074,177,120.15</b>	<b>88,479.85</b>	<b>100%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,002,347,600.00</b>	<b>2,976,424,353.15</b>	<b>25,923,246.85</b>	<b>99%</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,002,347,600.00	2,976,424,353.15	25,923,246.85	99%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>71,918,000.00</b>	<b>97,752,767.00</b>	<b>-25,834,767.00</b>	<b>136%</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,918,000.00	97,752,767.00	-25,834,767.00	136%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>159.00</b>	<b>159.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	154.00	154.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	0.00	100%

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>45,790,866.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>45,790,866.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,790,866.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,790,866.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,790,866.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>45790866.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>45,790,866.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,990,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,560,866.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь тайлант онд Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, зорилтын шалгуур үзүүлэлтийг хангах, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн бодлого, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын арга, хэлбэрийг боловсронгуй болгох, албаны шуурхай байдал, ажлын хариуцлага, сахилга бат, харилцааны соёлыг дээшлүүлэх, иргэдийн амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй, тэдэнд түргэн шуурхай үйлчлэх, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, алба хаагч бүрийн ажлын бүтээлч чанар үр дүнг ахиулж, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах, сахилга ёс зүйг сайжруулах, удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Цагдаагийн ерөнхий газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу байгууллагын 2021, 2022 оны санхүүгийн анхан шатны баримтад дотоод хяналт, шалгалтыг хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,214,672.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 2082.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	19,716.3	19,716.3
Авлага	44,027.6	14,691.6	(29,336.0)
Бараа материал	214,166.2	219,452.8	5,286.6
Үндсэн хөрөнгө	4,988,814.3	5,286,885.5	298,071.2
Хуримтлагдсан хөрөнгө	(1,034,418.8)	(1,326,074.2)	(291,655.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,212,589.4</b>	<b>4,214,672.0</b>	<b>(2,082.7)</b>
Өр төлбөр	00.0	129.2	-129.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,212,589.4	4,214,542.8	-1,953.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,212,589.4</b>	<b>4,214,672.0</b>	<b>-2,082.7</b>

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 19,716.3 мянган төгрөгөөр өссөн нь ЦЕГ-ын даргын 2022.12.20-ны өдрийн А/336 дугаар тушаалаар ахмадын санд 9,256.0 мянган төгрөг, 2022 оны цалингийн хэмнэгдсэн зардлаас 4,960.0 мянга, бусад хэмнэгдсэн зардлаас 9,771.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, ахмад настнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт, ахмадын баяр, цагаан сарын баяраар хүндэтгэл үзүүлэх зэрэг зардалд 13,328.0 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны 14,691.6 мянган төгрөг болж 29,336.0 мянган төгрөгөөр буурсан нь авлагаар бүртгэлтэй байсан 44,000.0 мянган төгрөгийн лед самбарыг- хүлээн авч авлагыг барагдуулсан, байгууллагын дансанд бүртгэлтэй байсан малтай холбоотой 14,691.6 мянган төгрөгийн авлага шинээр үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 219,452.8 мянган төгрөг болж 5,286.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 9,372.7 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 5,611.2 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 8,297.8 мянган төгрөгөөр, түлш шатах материал 8,131.5 мянган төгрөгөөр тус тус өсөж, барилгын засварын материал 10,442.0 мянган төгрөг, мал амьтад 16,066.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,286,885.5 мянган төгрөг болж 298,071.2 мянган төгрөгөөр өссөн нь ЦЕГ-аас 104,400.0 мянган төгрөгийн 2 ширхэг фургон автомашин, 14,804.1 төгрөгийн тоног төхөөрөмж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 173,343.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого авч, өмнөх оны авлагаар бүртгэлтэй байсан лед самбар, төсвийн хөрөнгөөр 1,705.1 мянган төгрөгийн хөрөнгө

худалдан авсан ба аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/26 дугаар тогтоолоор 41,681.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

“Цэлмэг өглөө” ХХК-д барилгын материалын өглөг 129.2 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,214,542.8 мянган төгрөг болж 1,953.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,707,765.6 мянга, үйл ажиллагааны орлогоос 71,918.0 мянга, нийт зарлагыг 4,779,683.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,845,156.0 мянган төгрөгөөр бууруулж, 2,934,527.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Богд, Жаргалант сумын сум дундын цагдаагийн тасгийн байр шинээр барих хөрөнгө оруулалтын ажил, алба хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал хасагдсантай холбоотойгоор төсөв буурсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 211,600.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,074,265.6 мянган төгрөгийн төсөв баталж, эх үүсвэрийг улсын төсвөөс 3,002,347.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 71,918.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,002,347.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 97,752.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд: Тусгай объектын харуул хамгаалалтын орлого 68,653.0 мянга, баривчилгаа болон эрүүлжүүлэхийн орлого 29,099.7 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлээр 3,074,265.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Нийт	3,002,347.6	2,976,424.3	25,923.3	99%
1	Хөтөлбөр 70704 Цагдаа	2,900,206.8	2,874,290.7	25,916.1	99%

2	Хөтөлбөр 70711- Шүүгч болон гэрч, хохирогч	102,140.8	102,133.6	7.2	100%
---	--	-----------	-----------	-----	------

Эх сурвалж: 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус цагдаагийн газар нь 2022 онд нийт 5 зорилт, 44 ажил арга хэмжээг хийж хэрэгжүүлнэ гэж Цагдаагийн ерөнхий газрын даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажилласнаас нийт ажил арга хэмжээг 90,2 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэн дүгнүүлэн ажилласан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн 100030012402 тоот дансаар нийт 45,790.8 мянган төгрөгийн орлого орсон. Үүнд аймгийн Засаг даргын захирамжаар 12,990.0 мянган төгрөг орсныг Алба хаагчдын шалгах төхөөрөмжийн сунгалтын үнэ болон согтуурал шалгах багаж худалдан авч зориулалтын дагуу зарцуулсан, 2021 оны давсан орлого 7,632.9 мянга, цагдаагийн хуучин байрны ашиглалтын төлбөр 5,518.0 мянган төгрөгийг халаалтын төлбөр, цэвэрлэгээ ариутгалын төлбөрт зарцуулж харилцахын үлдэгдэлгүй ажилласан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт

2022.11.21-ны өдрийн 01/367 дугаар албан бичгээр, 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,407,494.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 36,112.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 25,278.7 мянган тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ.

- Баянхонгор аймгийн Шүүхийн байгууллагын түүхт 80 жилийн ой тохиож байгааг тохиолдуулан 2 ажилтанд 90.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон, Сүүж амралтын газар амарсан 2 албан хаагчдад 224.0 мянган төгрөгийн томилолт олгосон нь энэ хуулийн 15.1.3. дахь “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” заалттай нийцэхгүй байна.

- НИК ХХК-д шатахууны урьдчилгаа 8,131.5 мянган төгрөгийг шилжүүлэн картад үлдэгдлээр тайлагнасан нь энэ хуулийн 15.1.6. “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” заалттай нийцэхгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-4, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 2,996,006.6 мянган төгрөгийн 30 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 316,445.9 мянган төгрөгийн 29 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 24,710.2 мянган төгрөгийн 82 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитыг 2022.11.03-2022.11.14-ны хооронд гүйцэтгэн 4,882.6 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэгдэж байгаа хөрөнгүүдийг аймгийн ИТХ-ын тогтоолыг үндэслэн хөрөнгөд орлогоор бүртгэж байх.

### **5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,882.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 4,882.6 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: Цагдаагийн байгууллагын 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад олгосон хоолны үнийг Цагдаагийн ерөнхий газрын санхүү аж ахуйн албаны 2021 оны 6/671 дугаар албан бичгээр цалингийн нэмэлт зардлын эдийн засгийн ангиллаас гаргахаар чиглэл ирүүлсэн байхад нягтлан бодогч 2022 оны 7, 9 дүгээр сарын хоолонд олгосон мөнгийг хоолны зардлын эдийн засгийн ангилалтаас гаргасан байсныг залруулсан.

Аудитаар нийт 10,437.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 783.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 9,653.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### **5.1 Төлбөрийн акт**

1. Ахмадын зөвлөлийн даргад төсвөөс 453.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцэхгүй батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын сангаас буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Баянхонгор аймгийн Шүүхийн байгууллагын түүхт 80 жилийн ойг тохиолдуулан 2 ажилтанд 90.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон, мөн 2 албан хаагчид амралтын газар амарч байхад 240.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5- батлагдсан төсвийг зориулалтын

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Худалдан авалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгчийн худалдан авалтыг е-баримтын бүртгэлтэй тулган шалгахад Явуугийн хэлхээ ХХК-ийн 15,220.5 мянган төгрөгийн е-баримт шивэгдээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган е баримтыг нөхөн мэдүүлж, цахим төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээг шилжүүлэх, бүртгэх

### **2. Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: НИК ХХК-ний шатахууны картад шатахууны 8131.5 мянган төгрөгийн нэг сарын нөөцийн шатахууны үлдэгдэлтэй гарсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, шатахууны нөөцийг зохистой хэмжээнд үлдэгдэлтэй байлгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Алба хаагчдад олгосон хоолны үнийг цалингийн нэмэлт зардлаас гаргахаар чиглэл ирүүлсэн байхад 2022 оны 7, 9 дүгээр сарын мөнгийг хоолны зардлаас гаргасан	1	4,882.6					1	4,882.6				
Дүн	1	4,882.6					1	4,882.6				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэмж урамшууллыг зардлаас ахмадын зөвлөлийн даргад урамшуулал олгосон.	1	453.6	1	453.6								
Баянхонгор аймгийн Шүүхийн байгууллагын түүхт 80 жилийн ойг тохиолдуулан 2 ажилтанд 90.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал, мөн 2 албан хаагчид амралтын газар амарч байхад 240.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон	1	330.0	1	330.0								
Бэлтгэн нийлүүлэгчийн худалдан авалтыг е-баримтын бүртгэлтэй тулган шалгахад Явуугийн хэлхээ ХХК нь 15,220.5 мянган төгрөгийн баримт шивэгдээгүй байна.	1	1522.1					1	1522.1				
Дүн	3	2,305.7	2	783.6			1	1522.1				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Төрийн хэмнэлтийн тухай хууль												
НИК ХХК-ийн шатахууны картад 8131.5 мянган төгрөгийн шатахуун нөөцөлсөн байна.	1	8,131.5							1		8,131.5	
Дүн	1	8,131.5							1		8,131.5	
Нийт дүн	1	8,131.5							1		8,131.5	

---oOo---